



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/357

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын сургалт арга зүйн техникийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор ухаалаг самбар худалдан авах зардалд 13,000,000 төгрөг зарцуулсугай.

2. Зардалд зарцуулагдах 13,000,000 төгрөг (арван гурван сая)-ийг Хөшөөт хөгжил сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 3.6 дахь "Сургалтын цахим платформ" хөтөлбөр, төслөөс тооцож гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Хөшөөт хөгжил сангийн гүйцэтгэх захирал (Т.Мягмардорж)-д тус тус зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Дэлгэрсайхан)-д даалгасугай.



Б.ДҮГЭРЖАВ